

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар А-29

Улаанбаатар  
хот

## Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.6, 7.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5 дахь заалт, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр батлагдаагүй тул 2016-2017 онуудад төсөл нь дэмжигдэж гэрээ байгуулсан боловч санхүүжилт нь олгогдоогүй, гэрээ байгуулаагүй нэгдүгээр хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд дэмжлэг үзүүлэх шийдвэрийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-21, А-94, А-125, А-126 дугаар тушаалуудын дагуу гэрээ байгуулсан боловч эх үүсвэрийн хүрэлцээнээс шалтгаалан санхүүжилтийг дутуу олгосон хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд олгосон санхүүжилтийн хэмжээгээр гэрээ шинэчлэн байгуулахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /С.Төгсбилэг/-д даалгасугай.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-125, А-126 дугаар тушаалаас энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжийн холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /С.Төгсбилэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлого, зохицуулалтын газар /М.Дондогдорж/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл тушаал хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайдын 2018 оны А-29 дүгээр тушаалын  
1 дүгээр хавсралт

Төсөлд дэмжлэг үзүүлэх шийдвэр хүчингүй болж  
байгаа иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт

д/д	Нэрс	Дэмжигдсэн дүн
1.	Оюуны хишиг ХХК	200,000,000
2.	Иргэн П.Наранцэцэг	60,000,000
3.	Иргэн Ж.Сарнай	100,000,000
4.	Монвурст ХХК	1,000,000,000
5.	Цагийн эрч ХХК	300,000,000
6.	Иргэн Л.Ганбаяр	30,000,000
7.	Иргэн Д.Даваахүү	200,000,000
8.	Эм эн ар си ХХК	300,000,000
9.	Иргэн А.Дашдорж	300,000,000
10.	Редстар клуб ХХК	300,000,000
11.	Евро ази констракшн ХХК	100,000,000
12.	Бүрэн луу ХХК	300,000,000
13.	Гэрэлт мөнх ундарга хоршоо	270,000,000
14.	Баянтал борц ХХК	300,000,000
15.	Ширээт онон ХХК	300,000,000
16.	Арвин сүлжээ ХХК	1,000,000,000
17.	Борталын хишиг ХХК	1,147,200,000
18.	Интосэ ХХК	1,000,000,000
19.	Хатан хармаг ХХК	200,000,000
20.	Сүлдэт хад ХХК	200,000,000
21.	Иргэн Ц.Бадамханд	320,000,000
	<b>Нийт</b>	<b>7,927,200,000</b>

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайдын 2018 оны А-29 дүгээр тушаалын  
2 дугаар хавсралт

Төслийн санхүүжилтийн хэмжээнд өөрчлөлт орж байгаа  
иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалт

д/д	Нэрс	Санхүүжилтийн дүн
1.	Наму дэвжих ХХК	200,000,000
2.	Уул далайн баялаг ХХК	100,000,000
3.	Дархангэрэл ХХК	300,000,000
4.	Номин Ендэрт ХХК	200,000,000
5.	Анивей ХХК	100,000,000
6.	Ти Жи И ХХК	300,000,000
7.	Алтан трейд ХХК	500,000,000
8.	Тайж гоёл ХХК	200,000,000
9.	Инжхами ХХК	250,000,000
10.	Доктор Мейк ХХК	700,000,000
11.	Монгол женетикс сервис ХХК	300,000,000
12.	Норбу агко ХХК	300,000,000
13.	Жи Пи Эм ХХК	200,000,000
14.	Цаст Согоот ХХК	500,000,000
15.	Тэнгэрийн марал ХХК	150,000,000
16.	Тайшир өргөө ХХК	375,000,000
17.	Батган агро ХХК	500,000,000
18.	Давхар өртөө ХХК	150,000,000
19.	Унирапропертийз ХХК	150,000,000
20.	Эм Эйч Пи ХХК	150,000,000
21.	Иргэн Б.Буянжаргал	150,000,000
22.	Хатан энхрий ХХК	200,000,000
23.	Энх ариун ундрага ХХК	500,000,000
24.	Очир өв продакшн ХХК	80,000,000
25.	Грийн фелд карне ХХК	300,000,000
26.	Веллдресс ХХК	150,000,000
27.	Тэмүүлэн гэсэр ХХК	500,000,000
28.	Алтанхөхий 9-н эрдэнийн оргил ХХК	500,000,000
29.	Ти ЭсТи косметикс ХХК	640,000,000
30.	Альфаконстракшн ХХК	1000,000,000
31.	ЭСУ ХХК	350,000,000
32.	Виндзор ХХК	840,000,000
33.	Хатиган болор ХХК	600,000,000
	<b>Нийт</b>	<b>11,435,000,000</b>